



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-39 дүгээр тогтоолын Хавсралт

УХН4937 2578697

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Хувилбар	1.0
Баталсан огноо	2023 оны 2 дугаарр сарын хх-ний өдөр
Баталсан	Төлөөлөн удирдах зөвлөл
Боловсруулсан	Хуулийн хэлтэс
Холбогдох эрх зүйн баримт бичгүүд	<ul style="list-style-type: none"> ▪ Компанийн тухай хууль ▪ Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодекс ▪ Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
Дагаж мөрдөх Нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох	<p>Банкны хэмжээнд</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батална.</p>

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ЗАРЛАХ
3. ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ
4. ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОХ, ХУРЛЫН ДЭГ
5. ТАВДУГААР ЗҮЙЛ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ
6. ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ
7. ДОЛДУГААР ЗҮЙЛ. ХУРАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ
8. НАЙМДУГААР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ХасБанк (цаашид Банк/Компани гэх)-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, хурлын зарыг хүргүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, саналаа өгөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үйл ажиллагаанд Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны баталсан Компанийн засаглалын кодекс, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам (цаашид “Хорооны журам” гэх), энэхүү журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг мөрдөн ажиллана.

1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байхаас үл хамааран энэхүү журмаар зохицуулагдана.

Хоёрдугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах

2.1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна.

2.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хууль болон Банкны дүрэмд заасан үндэслэлээр ТУЗ-өөс хэдийд ч зарлан хуралдуулж болно.

2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ын шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулна.

2.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасан дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

2.4.1. Хурал зохион байгуулах хэлбэр;

2.4.2. Хурал хуралдуулах газар /танхимаар зохион байгуулах бол/ буюу байршил, өдөр, цаг;

2.4.3. Хурлын хэлэлцэх асуудал;

2.4.4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

2.4.5. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;

2.4.6. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;

2.4.7. Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;

- 2.4.8. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
 - 2.4.9. Хурал даргалагчийн нэр, албан тушаал;
 - 2.4.10. Тооллогын комиссын дарга, гишүүдийн мэдээлэл;
 - 2.4.11. Хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчийг төлөөлөн оролцох тухай итгэмжлэлийг хүлээн авах сүүлийн хугацаа.
- 2.5. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 2.6. Тухайн хурлаар хэлэлцэх асуудалтай шууд холбоотой банкны эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.

Гуравдугаар зүйл. Хурлын зар хүргэх

- 3.1. Хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргүүлэхдээ Хорооны журмыг мөрдөж ажиллана.
- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон банкны албан ёсны цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- 3.3. Энэ журмын 3.2-т заасны дагуу зарыг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.
- 3.4. Хурлын зарыг энэ журмын 3.2-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан, албан бичиг зэрэг харилцаа холбооны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчид хүргэж болно.
- 3.5. Хорооны журмын 2.6-д заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.
- 3.6. Хурлын зард Хорооны журмын 3.7-д заасан мэдээллийг тусгана.

Дөрөвдүгээр зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, хурлын дэг

- 4.1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгон хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцно.
- 4.2. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.
- 4.3. Энэ журмын 4.1-д заасны дагуу итгэмжлэлийн үндсэн дээр хуралд оролцож байгаа итгэмжлэгдсэн төлөөлөгч нь энэ тухайгаа хурлын бүртгэл явагдаж байх үед Төлөөлөн

удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тооллогын комиссын даргад мэдэгдэнэ. Энэхүү итгэмжлэл нь зөвхөн тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүчинтэй байна.

4.4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохтой холбоотой энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг зохицуулахдаа Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийг баримтална.

4.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг хурал зарлан хуралдуулах шийдвэрийн хамт Хувьцаа эзэмшигчид бэлтэн хүргүүлнэ. Хувьцаа эзэмшигч хурлын дэгийг баримтлах үүрэг хүлээнэ.

Тавдугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал

5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д болон Банкны дүрэмд Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулахаар заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.2. Саналын эрхтэй энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасан журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах эрхийг эдэлнэ.

5.3. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь энэхүү журмын 5.2-д заасны дагуу гаргасан саналыг хэлэлцэхдээ Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн баримталж ажиллана.

5.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхийг хориглоно.

Зургаадугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах

6.1. Хурлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

6.1.1. Танхимаар

6.1.2. Цахимаар /мэдээлийн технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах/

6.1.3. Хосолсон /танхим болон зайнаас/

6.2. ТУЗ нь энэхүү журмын 6.1-д заасан хурал зохион байгуулах хэлбэрээс сонгож, хурлыг зохион байгуулна.

6.3. Хурлыг цахимаар, эсхүл хосолсон хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд Хорооны журмын холбогдох зохицуулалтыг удирдлага болгоно.

6.4. Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасан эрх бүхий этгээдээс зарласан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг хангахад банкны удирдлага болон эрх бүхий албан тушаалтан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах үүрэгтэй.

- 6.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбоотой зардлыг банк бүрэн хариуцна.
- 6.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор хурал зохион байгуулах комисс байгуулж болно.
- 6.7.Хурал зохион байгуулах комисс (хэрэв байхгүй тохиолдолд Тооллогын комисс) нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалт, хурлын явцад уг хуралд оролцогч бүх хувьцаа эзэмшигч санал бодлоо илэрхийлж, өөрийн сонирхсон асуултаяа тавьж, зохих хариултаа авах боломжийг бүрдүүлсэн байна.
- 6.8. Хурлыг 08.00 цагаас 22.00 цагийн хооронд зохион байгуулна.
- 6.9. Хурлын зохион байгуулах комисс (хэрэв байхгүй тохиолдолд Тооллогын комисс) хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн зохих бүртгэлийг үндэслэн холбогдох бичиг баримтыг шалгаж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулна.
- 6.10. Тооллогын комисс нь хуралд дараах эрх, үүрэгтэйгээр оролцоно. Үүнд:
- 6.10.1. Тухайн хуралд цаасан саналын хуудсаар болон цахимаар саналаа урьдчилан өгсөн болон биеэр оролцохоор ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн ирцийг тогтоож, хурлын даргад мэдэгдэх;
- 6.10.2. Тооллогын комисс санал өгөх журмыг хуралд оролцогчдод дэлгэрэнгүй танилцуулах ба саналын хуудас, санал өгөх программ хангамжийг хэрхэн ашиглах буюу хэрхэн саналаа өгөх, ямар тохиолдолд хувьцаа эзэмшигчийн өгсөн санал, саналын хуудас хүчингүй болох, урьдчилан саналаа өгөх сүүлийн хугацаа, хуралд төлөөлж оролцох итгэмжлэлийг хүлээн авах сүүлийн хугацаа, санал хураалт дуусах хугацаа, саналыг тоолж дуусах хугацаа зэргийн талаар нэг бүрчлэн тайлбарлаж, мэдээлнэ.
- 6.11. Холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол компанийн нэг хувьцаа нэг саналын эрхтэй байж, саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгнө. Кумулятив аргаар санал хураахад энэ заалт хамаарахгүй.
- 6.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив арга (энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцэх саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигч нь өөрийн хувьцаанд ногдох саналаа бүгдийг нь нэг хүнд эсхүл хэд хэдэн хүнд хуваан өгөх эрхтэй)-аар сонгоно.
- 6.13. Хувьцаа эзэмшигчийн эчнээ саналыг цаасаар болон цахим саналын хуудсаар авах ба саналын хуудас нь Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 6.14. Хэрэв хуралд оролцогч этгээд нь итгэмжлэлийн үндсэн дээр хуралд оролцож байгаа бол санал өгөх, хуралд оролцохдоо тооллогын комисст холбогдох итгэмжлэлийг эх хувиар нь хавсарган өгнө. Хэрэв хурлыг цахимаар зохион байгуулж байгаа бол холбогдох итгэмжлэлийг хурал болохоос өмнө буюу холбогдох баримт бичгийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй цахим шуудангаар урьдчилан

ирүүлсэн байна. Тооллогын комисс хуралд төлөөлж оролцох итгэмжлэлийг хүлээн авах эцсийн хугацааг зарлана.

6.15. Тооллогын комисс саналыг тоолон, санал хураалтын үр дүнг нэгтгэн дүгнэж, дүнгийн тухай шийдвэр гаргана. Уг шийдвэрт тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, шийдвэрийн үнэн зөвийг хариуцна.

6.16. Тооллогын комиссын дарга нь гаргасан шийдвэрээ Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалагчид өргөн барина.

6.17. Тухайн хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга хурлаас гарсан шийдвэрт гарын үсэг зурж, банкны тэмдгийг дарж баталгаажуулна.

6.18. Банк нь хурлын шийдвэрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 56 дугаар зүйлийн 56.1.6-д заасны дагуу нэн даруй нийтэд мэдээлж, Хорооны журмын 2.10-д заасан холбогдох бичиг баримт, мэдээллийг хуульд заасан хугацаа буюу хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад Хорооны журмын дагуу тус тус хүргүүлнэ.

Долдугаар зүйл. Хурал хүчин төгөлдөр болох

7.1. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

7.2. Энэхүү журмын 7.1-д заасан хувь хүрээгүй бол хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг Төлөөлөн удирдах зөвлөл товлох бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно.

7.3. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад ажлын 4 өдөрт багтаан тус тус хүргүүлнэ.

7.4. Энэ журмын 7.2-т заасны дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын 7-аас доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

7.5. Хойшлогдсон хурлыг зохион байгуулах, хурлын ирцийг тогтоохдоо Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

Наймдугаар. Хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд банкны дотоод журам болон холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Энэхүү журмын хэрэгжилтэд Төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.